

Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралт

НЭГ. “ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл
1.	Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрийн тайлан, УИХ-ын тогтоол, 1998, №29	Хөтөлбөрийн зорилго: Монгол орны экологийн тэнцлийг хангахад онцгой ач холбогдол бүхий газар нутгийг хамарсан тусгай хамгалалттай газар нутгийн сүлжээг өөрийн орны өвөрмөц нөхцөл байдал болон олон улсын жишиг, хандлагад нийцүүлэн хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тогтооход оршино.
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв нийт 6,5 тэрбум төгрөг: 1. Улсын төсвийн хөрөнгөөр 550,3 сая төгрөгөөр Горхи Тэрэлжийн БЦГ, Хөгнө Тарнын БЦГ-ын хамгаалалтын захиргааны байрыг барьж гүйцэтгэв. 2. Байгаль, зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газар (WCS) Говийн бага ДЦГ-ын ХЗ-д SMART програмд ашиглагдах GPS зөөврийн компьютер, дуу хураагуур, зэрэг 19.000.000 төгрөгний үнэ бүхий эд хөрөнгийг хамгаалалтын захиргаанд хүлээлгэж өгсөн. 3. ADB төслийн хүрээнд төслийн үйл ажиллагаа нээсэнтэй холбогдуулан төслийн нэгж, салбар болон хз-д 100.873\$ үнэ бүхий машин, мотоцикл, оффис тавилга, тоног төхөөрөмжийг хүлээлгэж өгсөн.
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БОАЖЯ-ны ТХНУГ Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: - Орон нутгийн захиргааны байгууллага - ТХГН-ийн Хамгаалалтын захиргаад
4.	Хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1: Байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцлийг хангах, байгалийн баялгийг арвижуулах, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах зорилгоор байгалийн бүс бүслүүрийн үндсэн шинж, иж бүрдлийг төлөөлсөн, онцгой ач холбогдол бүхий газар нутгаар ТХГН-ийн сүлжээг өргөжүүлж, нийт улсын нутаг дэвсгэрийн 30-аас доошгүй хувьд хүргэнэ. Зорилт 2: Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай

		хууль тогтоомжийг боловсронгуй болгож сүлжээг хөгжүүлэх, тусгай хамгаалалттай газар нутаг болон түүний орчны бүсэд амьдарч буй хүмүүсийг тухайн нутгийн төлөвлөлт, хамгаалалтын үйл ажиллагаанд өргөнөөр харуулан, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.		
5.	Зардал	Төсөв 2016	Гүйцэтгэл	Хувь
		6.5 сая	6.5 сая	100%
		Мөн ТХНУГ-т хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрөөс тоног төхөөрөмжөөр хангасан		
	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорхи талбарт бичнэ		
6.	1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:	2016 оны байдлаар ТХГН-ийн сүлжээг үе шаттайгаар өргөжүүлж ирснээр нийт 27,9 сая га талбай бүхий 102 байршил газар нутгийг улсын тусгай хамгаалалтад хамруулаад байгаа нь нийт нутаг дэвсгэрийн 17,8 хувийг эзэлж байна. Мөн 2017 оны 3 дугаар сарын байдлаар сум, аймгийн ИТХ-ийн шийдвэрээр орон нутгийн тусгай хамгаалалттай газарт 57.9 сая га талбай бүхий 2360 газар хамрагдаад байгаа нь Монгол Улсын нийт газар нутгийн 37.06 хувийг эзэлж байна.		
	2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн2: Санамж: Хүрэх гол үр дүнг бичнэ.	<p>1.“Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль” 1994 он, “Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль” 1998 онд батлагдсаныг хөгжлийн өнөөгийн хандлага, нийгэм эдийн засгийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинэчлэн найруулж, хуулийн төслийг холбогдох талуудын оролцоотой боловсруулан, БОАЖ-ын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлснээр хуралдаанаар дэмжигдэж, УИХ-д өргөн барихаар төлөвлөн ажиллаж байна. Сангийн сайдтай хамтран баталсан хуулийн төслийн үзэл баримтлал, шинэчилсэн найрууллагын төсөл болон холбогдох материалуудыг хүргүүлэн батлуулсан бөгөөд засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор дахин батлуулахаар бэлтгэсэн.</p> <p>2.“Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа дуусч байгаатай холбогдуулан, үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр шинэчилсэн төслийг боловсруулан, хөтөлбөрийн үзэл баримтлалыг 2015.10.28-ны өдөр Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлж, Хууль зүйн яаманд хүргүүлэн батлуулсан. Мөн Тусгай хамгаалалттай газар нутгийн Үндэсний хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт, үзэл баримтлал, УИХ-ын тогтоолын төсөл, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, Засгийн газрийн гишүүдээс санал авч УИХ-ын тогтоолын</p>		

төслийг эцэслэн 2016 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 01/3313 албан тоотор холбогдох материалын хамт Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Одоогийн байдлаар Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор үзэл баримтлалын төслийг батлуулахаар ХЗДХЯ-д хүргүүлэхээр ажиллаж байна.

Хөтөлбөрийн хавсралтаар 2016-2030 он хүртэлх хугацаанд Улсын тусгай хамгаалалтад хамруулах газар нутгуудыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрэмбэлэн, жагсаалтыг аймаг, сумдаар гаргаж, ЗГХЭГ-т хүргүүлэв.

3. ТХГН-ийн сүлжээний хэмжээнд боловсон хүчнээр хангах асуудал шийдвэрлэгдэж, тус сүлжээнд 607 хүн ажиллаж байна. Байгаль хамгаалагчид Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг гэрээгээр хариуцуулах бодлогын баримт бичиг болон шалгуур үзүүлэлтийг боловсруулан талуудын хэлэлцүүлгийг БОАЖЯ-нд зохион байгуулж, саналыг тусган эцэслэж, Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Мөн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг гэрээгээр хариуцуулах боломжит газруудын судалгааг гаргасан.

5. Сургалт, сурталчилгааны ажлыг өргөн хүрээнд /төв болон орон нутгийн хэмжээнд/ зохион байгуулж, "ТХГН-ийн үүрэг, ач холбогдлын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилж, хүн амын мэдлэг, мэдээллийн түвшинг байнга дээшлүүлнэ" гэсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор олон талт ажлуудыг хэрэгжүүлснээр иргэд болон орон нутгийн захиргаадын байгаль хамгаалах ухамсар, ойлголт, тэдний хамтран ажиллах сонирхол, хандлага ихээхэн нэмэгдсэн.

3-р зорилтын хүрээнд:
Хүрэх үр дүн 3:

1. "Орчны бүсийн менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачилсан зөвлөмж"-ийн дагуу 30 орчны бүсийн менежментийн төлөвлөгөө боловсруулан холбогдох сумдын Засаг дарга нар батлан хэрэгжүүлж ажиллаж байна.

2. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын судалгааг улсын хэмжээнд шинэчлэн нэгдсэн мэдээллийг гаргав.

3. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн "Эко бүс нутаг" дэд хөтөлбөрийн Засгийн газрын тогтоол, үзэл баримтлал, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний

		<p>төлөвлөгөөг боловсруулж, 2016 оны 04 дүгээр сарын 25-нд 01/2406 тоот албан бичгээр Засгийн газрын гишүүдээс санал авч Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн боловч Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор буцаасан, ТХГН-ын хуулийн төсөл батлагдмагц дахин хүргүүлэхээр бэлтгэв.</p> <p>4. Улсын тусгай хамгаалалттай газрын 3 хамгаалалтын захиргааны менежментийн төлөвлөгөөг шинэчилсэн зааврын дагуу /МИРАДИ программ/ шинэчлэн боловсруулж, батлуулав.</p> <p>5. Говь гурван сайханы байгалийн цогцолборт газар, Ээд хантайн бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Хан хөхий нурууны Улсын тусгай хамгаалалттай газрын захиргаад болон аялал жуулчлал хөгжиж буй зарим хамгаалалтын захиргаад батлагдсан аяллын маршрутын дагуу тухайн газруудад тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.</p>
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Хөтөлбөрийн 2 дахь үе шатны хэрэгжилтийн хугацаа дуусч байгааг дүгнэхэд, дараах <u>ололт, үр дүн гарав</u>. Үүнд:</p> <p>1.Тогтвортой хөгжлийн талаарх төрийн бодлогын зорилтууд хэрэгжиж, үр дүнгээ өгч эхэлсэн.</p> <p>2. Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр /УИХ, 1988/ 3.4-т “Байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцлийг хангах, байгалийн баялгийг арвижуулах, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах зорилгоор байгалийн бүс, бүслүүрийн үндсэн шинж, иж бүрдлийг төлөөлсөн, экологийн онцгой ач холбогдол бүхий газар нутгаар тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, нийт улсын нутаг дэвсгэрийн 30-аас доошгүй хувьд хүргэнэ”, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал /УИХ, 2010/, Ногоон хөгжлийн бодлого /УИХ, 2014/ 3.2.1-т “Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах”, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030 /УИХ, 2016/ “Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр /УИХ, 2016/-ийн “Байгалийн унаган төрхөө хадгалсан газар, цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг улсын тусгай</p>

хамгаалалтад авна.” хэмээн тодорхойлсон төрийн бодлого зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор газар нутгийг улсын тусгай хамгаалалтад хамруулахаар судалгаа хийж, үндэслэлийг боловсруулав. Түүнчлэн 7 аймгийн 12 сумын нутаг дэвсгэрийг хамарсан 4 өргөтгөл, 2 байгалийн нөөц газар, 1 дурсгалт газрыг улсын тусгай хамгаалалтад авснаар талбайн хэмжээ 1 840 267.59 га-аар буюу нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь 1.18 хувиар нэмэгдэж, 29 039 667.59 га болж, улсын тусгай хамгаалалттай нийт газар нутгийн 18.5 хувийг эзлэх болно.

3. Хамарсан экосистем:

- Улсын хэмжээнд 12.4 сая га талбай бүхий 20 дархан цаазат газар, 11.7 сая га талбай бүхий 32 байгалийн цогцолборт газрууд нь байгалийн үндсэн бүс, бүслүүрийн унаган төрхийг хадгалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад голлох үүрэг гүйцэтгэж байна.

- Монгол орны өндөр уулын **11,1-40,7%**, ойн **9,9-31,1%**, хээрийн **4,2-7,6%**, ус, намгархаг газрын **13,9-79,0%**, говь цөлийн **13,9-74,1%**, өвөрмөц экосистемийн **9-79,3%** нь ТХГН-ийн сүлжээнд хамрагдсан байна.

- Монгол орны ойн сангийн талбайн **45** орчим хувь, томоохон гол, мөрний урсац бүрэлдэх эх болон гадаргын усны эзлэх нутаг дэвсгэрийн **10** орчим хувь, устах аюулд орсон болон устаж болзошгүй **300** амьтан, ургамлын үндсэн тархац нутгийн **60** гаруй хувь, байгалийн үзэсгэлэнт газар, байгаль, түүх, соёлын үнэт өв бүхий газар нутгийн **80** гаруй хувийг тус тус улсын тусгай хамгаалалтад хамруулснаар байгалийн унаган төрх, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах, байгалийн баялагын нөөцийг хамгаалахад үнэлж барашгүй үүрэг гүйцэтгэж байна.

- Эх нутагтаа 100-аад жилийн өмнө устаж үгүй болсон дэлхийн устах аюулд орсон тахь адууг 4 тусгай хамгаалалттай газарт сэргээн нутагшуулснаар тэдгээрийн тоо толгой 575 хүрч, дэлхийд туршлага болохуйц үр дүнтэй ажлыг амжилттай хэрэгжүүлж байна.

4.Экосистемийн үйлчилгээ, аялал жуулчлал:

- Тусгай хамгаалалттай газар нутагт аялал, жуулчлалын 360 орчим баазын 80 гаруй хувь нь байршиж, жилдээ ойролцоогоор 400 мянга орчим гадаадын жуулчид, аялагчдыг хүлээн авч, ажлын байр бий болгож, аж ахуйн нэгж байгууллагын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж байна.

5.Олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлэлцээрт

хамрагдсан байдал:

- Дэлхийн байгаль, соёлын өвд: 2003 онд Увс нуурын ай савын ДЦГ, 2004 онд Орхоны хөндий соёлын дурсгалт газар, 2011 онд Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор, 2015 онд Бурхан Халдун уул тус тус бүртгэгдсэн.

- Дэлхийн Хүн ба шим мандлын нөөц газрын сүлжээнд: 1990 онд Говийн их ДЦГ, 1996 онд Богдхан уулын ДЦГ, 1997 онд Увс нуурын ай савын УТХГ, 2004 онд Хустайн нурууны БЦГ, 2005 онд Дорнод монголын УТХГ, 2007 онд Монгол Дагуурын ДЦГ, 2012 онд Хөвсгөлийн БЦГ /шийдвэр хараахан гараагүй/

- Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц /РАМСАР/-ийн хавсралтад: Монгол дагуурын ДЦГ(1992), Увс нуурын ай сав (1993), Хөвсгөл нуур (1992), Хорго тэрхийн цагаан нуур (1995), Хар ус нуур (1997), Хяргас.Айраг нуур (2000), Онон.Балжийн гол (2000), Булган гол (1995), Яхь нуур (1998), Хүйсийн найман нуур (1992), Ганга нуур (1993) хавсралтад бүртгэгдээд байна.

Цаашид анхаарах асуудлууд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийн хилийн зааг, менежментийн эрх зүйн зохицуулалтыг шинэчилж, байгальд ээлтэй аялал жуулчлал, ногоон хөгжлийн түшиц газар болгон хөгжүүлнэ.” зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын хаврын чуулганаар батлуулан мөрдүүлэх;
2. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Байгалийн унаган төрхөө хадгалсан газар, цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг улсын тусгай хамгаалалтад авна.” зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Байгалийн унаган төрх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгаль, түүх соёлын үнэт өв болон ховордсон амьтан, ургамлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг сааруулах, дасан зохицох шаардлагыг харгалзан зайлшгүй шаардлагатай газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах асуудлыг үе шаттайгаар УИХ-д оруулж, хэлэлцүүлэх;
3. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежмент санхүүжилтийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ бусад нэмэлт эх үүсвэрийг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар хамгаалалтын

		<p>менежментийг сайжруулан, ногоон хөгжлийн түшиц газар болгон хөгжүүлэх;</p> <p>4. Тусгай хамгаалалттай газар нутгуудын менежментийг бүхэлд нь буюу хэсэгчлэн иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, мэргэжлийн болон төрийн бус байгууллагуудад тодорхой нөхцөл болзолтойгоор хариуцуулан улсын төсвийн ачааллыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p>				
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ					
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		85%	3	80%	90 %	80%
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ				
		... %				